

**Петро Матад Лимитед (“Петро Матад” эсвэл “Компани”)**

**Давсан Толгой-2 Хайгуулын Цооногийн Өрөмдлөг Эхэлсэн тухай болон Үйл ажиллагааны талаархи Шинэчилсэн мэдээлэл**

*ДТ-2 талбайн цооногийн өрөмдлөгийг эхлүүлсэн тухай*

Монгол Улсын цагаар 2010 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 13:15 цагт (Британы Стандарт Цагаар 2010 оны 08 дугаар сарын 28-ны өглөөний 06.15 цагт) Давсан Толгой-2 (“ДТ-2” гэх) хайгуулын цооногийн өрөмдлөгийг эхлүүлсэнийг Петро Матад (AIM:MATD) албан ёсоор мэдэгдэж байна.

ДТ-2 цооногийг ойролцоогоор 1300 метрийн үнд хүртэл босоо чиглэлээр өрөмдөхөөр төлөвлөж байна. ДТ-2 цооногийн өрөмдлөгийг Компанийн гэрээт гүйцэтгэгч болох БНХАУ-ын Ансай Юхуа Ойл Тек Компани (Ansaï Yuehua Oil Tech Company Ltd) гүйцэтгэж байна. Өрөмдлөгийн ажил нь 25 өдөр үргэлжилнэ гэж үзэж байгаа бөгөөд өрөмдлөг дууссаны дараа эсвэл тухайн ажлын явцтай уялдуулан дараагийн мэдээллийг хүргэх болно. ДТ-2 цооног нь Монгол Улсын зүүн хэсэгт байрлах ХХ талбайд Бүтээгдэхүүн Хуваах Гэрээний дагуу Петро Матадын 2010 онд явуулах гурван цооногийн өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа хоёр дахь хайгуулын цооног бөгөөд ХХ талбай нь Компанийн Монгол Улсад эзэмшиж, үйл ажиллагаа явуулж буй хайгуулын гурван талбайн нэг юм. ДТ-2 цооног нь, бүхэлдээ газрын тосны илэрцтэй, шаврын хий агуулсан 71 метрийн урттай Цагаанцавын Формац хэмээх тогтоц бүхий ДТ-1 талбайгаас урагшаа буюу баруун урд тз ойролцоогоор 930 метрийн зайд байрлана. (2010 оны 07 дугаар сарын 15, RNS Дугаар 4238P-г харна уу)

Хоёрдахь цооногийг ДТ-1 –ээс баруун зүгт 4 километрийн зайд Баруун Давсан Толгой хэмээх салангид бүтэц дээр байршуулах саналыг дахин нягталж үзсэн бөгөөд ДТ -1 цооногийн нааштай үр дүнг харгалзан үзсэний үндсэн дээр энэхүү голлох бүтцийн талаархи ойлголтыг сайжруулах үүднээс Компани ДТ -2 цооногийг Давсан Толгойн бүтцийн гол хэсэгт, ДТ -1 цооногийн байрлаж буй бүтэц дээр байрлуулахаар шийдсэн.

Энэ жил өрөмдөх гурван цооногийн аль нэгт олборлолтын туршилт явуулах бөгөөд аль цооногт туршилт хийхийг хөтөлбөрийн сүүлээр шийдвэрлэх болно.

*IV ба V талбайн хайгуул*

IV болон V талбайд явуулж буй 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажлын гуравны хоёр орчмыг гүйцэтгээд байна. Талбайгаас авсан мэдээллийн урьдчилсан тайлалаар хотгор газрууд нь хүндийн хүчний судалгааны дүгнэлтэнд зааснаас илүү гүн болох нь нотлогдсон бөгөөд нүүрстөрөгчийн хураагуур үүсгэх боломжтой бүтэц оршиж буйг баталж байна.

Монгол Улсын төв хэсэгт орших эдгээр талбайнуудад хүндийн хүчний дэлгэрэнгүй судлагааг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүгэн хянаж, зассан болно. Доктор Күүгэн нь Хойд Америк болон олон улсын газрын тосны хайгуул, ашиглалтын салбарт 29 жил ажилласан туршлагатай Газрын тосны геологич юм.

Тэрээр Америкын Газрын Тосны Геологичдын Нийгэмлэг болон Америкын Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

*Компанийн талаархи нэмэлт мэдээллийг:*

Петро Матад Лимитед  
Даглас Жэй МакГэй – Гүйцэтгэх Захирал  
+976 11 331099

**Петро Матад Лимитед компанийн тухай**

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашигласныг дүрлэл явуулахад чиглэсэн группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах тухай гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол Улсын зүүн алсын нутаг дэвсгэрт орших 14,250 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий газрын тосны талбай болох XX талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх). Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайнууд нь Монгол Улсын төв хэсэгт орших бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 хавтгай дөрвөлжин километр талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V тоот компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан бөгөөд компанийн албан ёсны үртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1Кью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг болно.